

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН**

**НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН  
ДҮРЭМТ ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
НЭЭЛТТЭЙ ҮНИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ**

Үнийн санал авах  
баримт бичгийн нэр  
/дугаар:

**Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны  
ажилтнуудын дүрэмт хувцас нийлүүлэх  
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй  
үнийн санал авах урилга.  
ИНЕГ/УЗ/ТББ/Б-27/20**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Иргэний нисэхийн ерөнхий газар]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН ДҮРЭМТ ХУВЦАС**–г нийлүүлэх тухай нээлттэй үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Худалдан авах ажиллагааны тасагг /11-282127/ ирж өөрийн биеэр авна.

Үнийн саналыг **2020 оны 10 дугаар сарын 23-ны 09.00 цаг**-аас өмнө **Иргэний нисэхийн ерөнхий газрын Худалдан авах ажиллагааны тасагт үнийн саналыг хэвлэмэл байдлаар битүүмжилж ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **[2020 оны 10 дугаар сарын 23 ]**-ны өдрийн **[09:30 цаг]**-т нээнэ.

Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Иргэний нисэхийн ерөнхий газрын 108 тоот  
Худалдан авах ажиллагааны тасаг Утас: 71282127**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br><i>(а) Маягтын дагуу Үнийн санал;</i><br><i>(б) Маягтын дагуу Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</i><br><i>(в) Маягтын дагуу Өмнө болон одоо хэрэгжүүлсэн гэрээний мэдээлэл;</i><br><i>(г) Техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасныг нотлох баримт</i><br><i>(д) 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/</i> |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Захиалагч нь: <i>Иргэний нисэхийн ерөнхий газар</i>
<b>ТӨӨЗ 1.1</b>	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b><i>Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны ажилтнуудын дүрэмт хувцас нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг</i></b> <b><i>ИНЕГ/УЗ/ТББ/Б-27/20</i></b>
<b>ТӨӨЗ 1.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b><i>3 Багцад хуваагдана.</i></b>
<b>ТӨӨЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b><i>ИНЕГ-ын 2020 оны урсгал зардлын хөрөнгөөр</i></b>
	<b>Б. Үнийн саналын баримт бичиг</b>
<b>ТӨӨЗ 8.1</b>	Захиалагчаас үнийн саналын баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b><i>Хан-Уул дүүрэг 21-р хороо. Иргэний нисэхийн ерөнхий газарХудалдан авах ажиллагааны тасаг. 108 тоот өрөө.Утас: 71282127</i></b>
<b>ТӨӨЗ 8.1</b>	Үнийн саналын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас <b><i>ажлын 5 хоногоос багагүй байна.</i></b>
	<b>В. Үнийн санал бэлтгэх</b>
<b>ТӨӨЗ 12.1 (ё)</b>	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар заавалируулна. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li><b>1.</b> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li><b>2.</b> Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li><b>3.</b> Татварын албаны цахим тодорхойлолт /нээсэн өдрийн байдлаар өргүй байх Бар код гаргацтай тод байх шаардлагатай./</li> <li><b>4.</b> Нийгмийн даатгалын тодорхойлолт</li> <li><b>5.</b> Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li><b>6.</b> Харилцагч банкнаас өр төлбөргүй гэсэн тодорхойлолт</li> <li><b>7.</b> Захиалагчийн тавьсан ажлын даалгаврын шаардлагыг хангасан байх.</li> <li><b>8.</b> Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон байх шаардлагатай</li> <li><b>9.</b> Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй</li> <li><b>10.</b> Ажлын даалгаврын дээж бүрээс загвар ирүүлэх. /Ирүүлээгүй бол шаардлага хангаагүй гэж үзэж тендерээс татгалзана/</li> </ol>
<b>ТӨӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)</b>	Бараа хүргэгдэх газар: <b><i>Иргэний нисэхийн ерөнхий газар. ИнкотермсийнDDP нөхцөл.</i></b>
<b>ТӨӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)</b>	“Бараа хүргэгдэх эцсийн цэг ( <b><i>Иргэний нисэхийн ерөнхий газар</i></b> )”: Хан-Уул дүүрэг 21-р хороо, Буянт-Ухаа, <b><i>Иргэний нисэхийн ерөнхий газар. ИнкотермсийнDDP нөхцөл.</i></b>

ТООЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>Аудитаар баталгаажуулсан Сүүлийн 1 жил. /2019/</i>
ТООЗ 18.1 (г)	Ижил төстэйгэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 2 жилд 1-оос доошгүй тухайн гэрээт ажлыг хүлээж авсан акт, эсвэл гэрээ дүгнэсэн тодорхойлолтын хамт ирүүлэх.</i> ИНЕГ-тай 2019 онд гэрээ байгуулсан бол гэрээ дүгнэсэн акт ирүүлэх. /Гэрээний үүргээ биелүүлээгүй болон ноцтой зөрчсөн тохиолдолд үнэлгээнд харгалзах үндэслэл болно./
ТООЗ 18.2 (а)	Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 1 жилийн борлуулалтын орлогын нийлбэр нь төсөвт өртгийн 100%-тай тэнцэх төгрөгөөс доошгүй байна.</i>
<b>Г. Үнийн санал ирүүлэх</b>	
ТООЗ 23.3 (б)	Үнийн санал хүлээн авах захиалагчийн хаяг: Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг 21-р хороо, ИНЕГазар, Утас: 71282127</i> Аймаг, хот: <i>Улаанбаатар хот</i> Шуудангийн дугаар: <i>210134</i> , Улс: <i>Монгол Улс</i> Үнийн санал хүлээн авах этгээд: <i>Худалдан авах ажиллагааны тасаг 108 тоот өрөө.</i>
ТООЗ 23.3 (в)	Үнийн саналын шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор үнийн саналын гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ. <i>Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны ажилтнуудын дүрэмт хувцас нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнийн саналын баримт бичиг ИНЕГ/УЗ/ТББ/Б-27/20</i>
ТООЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <i>2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>09 цаг 00 минут</i>
<b>Д. Үнийн саналыг нээх, үнэлэх</b>	
ТООЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <i>Хан-Уул дүүрэг 21-р хороо, Иргэний нисэхийн ерөнхий газар</i> Давхар болон өрөөний дугаар: <i>1 давхар, Худалдан авах ажиллагааны тасаг 108 тоот</i> Аймаг, хот: <i>Улаанбаатар хот</i> Шуудангийн дугаар: <i>210134</i> , Улс: <i>“Монгол Улс”</i>  Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <i>2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр.</i> Цаг: <i>09 цаг 30 минут.</i>

# **БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

## **АГУУЛГА**

1. БАРААНЫ НЭР ТӨРЛИЙН ЖАГСААЛТ БОЛОН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ ИРҮҮЛЭХ
2. ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВААРЬ ИРҮҮЛЭХ
3. АЖЛЫН ДААЛГАВАР ХАНГАСАН МЭДЭГДЭЛ ИРҮҮЛЭХ

# 1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө ].

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа /хуанли хоногоор/		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа /захиалагчийн шаардлага /	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа /захиалагчийн шаардлага/	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойлолтыг бичих]	[нэгжийн тоо ширхэгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]
Багц-1: Дүрэмт хувцас	Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу	Эрэгтэй 64 Эмэгтэй 28	хос	ИНЕГ	30	60	
Багц-2: Цагаан цамц ханцуйгүй	Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу	Эрэгтэй 64 Эмэгтэй 28	ширхэг	ИНЕГ	30	60	
Багц-2: Цагаан цамц ханцуйтай	Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу	Эрэгтэй 64 Эмэгтэй 28	ширхэг	ИНЕГ	30	60	
багц-2: Зангиа	Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу	92	Ширхэг	ИНЕГ	30	60	
Багц-3: Ноолууран майк	Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу	92	Ширхэг	ИНЕГ	30	60	



## 2. Техникийн тодорхойлолт

### НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ НИСЛЭГИЙН УДИРДАГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦАС"-НЫ АЖЛЫН ДААЛГАВАР

#### 1. БАГЦ-1: ДҮРЭМТ ХУВЦСАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Д/Д	МАТЕРИАЛ	ШААРДЛАГА	ӨНГӨ	ТАЙЛБАР
<b>НЭГ.Эрэгтэй пиджак</b>				
1.	Гадна өнгө	Өнгө амархан алдахгүй , нийлэг бус хөвөн даавуун материал, тоос татахгүй үрчийхгүй байх -Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна. -Хүний биед дээд зэргээр тохиромжтой байх бөгөөд биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх	Хар хөх	
2.	Дотор өнгө	-	Хар хөх	
3	Дотрын материал	Дотрын материалын зориулалт бүхий амархан сэмэрч гэмтэхээргүй материал, хөнгөн чанартай салхи нэвтрүүлдэг, будаг гардаггүй байх	Хар хөх	Дотрын материал нь 100% Ацетат байх
4	Зах, мөр	Зах болон мөр нь хатуулгатай байх, атираагүй, үрчийхгүй, хөндийрч сэмрэхгүй байх	Хар хөх	Захны өргөн-5см Захны урт-40см
5	Урд тал	Урд талдаа 2 ширхэг товчтой байна.	Хар хөх	Пиджакны доод талаас 23см, урд талын 2 товчны хоорондын зай 10см байна.
6	Бардовка /Энгэрийн хатуулга/	Энгэр дөрвөлжин ташуу хэлбэртэй байна. Дээд талаас доошоо нарийссан байна.	Хар хөх	Урт-23см Дээд өргөн-8см
7	Халаас	Урд талын энгэр талд байрлалтай 1 халаас байна. Халаас нь зэргийн тэмдэг зүүхэд тохиромжтой байх Урд талын доод талд 2 ширхэг далд халаас байна. Дотор халаас баруун энгэрийн дээд талд 1, зүүн энгэрийн дээд доод талд халаас байх ба тэгш өнцөгт хэлбэртэй байна.	Хар хөх	Халаасны өндөр-24см Халаасны хэмжээ-15см Халаасны гүн 20см
8	Лого	Урд талд: Энгэрийн карманы доод талд албаны лого байрлана	Хар, шар өнгийн	Тусад нь ширж хатгаж бэлтгэсэн логог энгэрийн халааснаас доош 4см-н түвшинд халаасны эмжээртэй паралель оёсон байна
9	Ханцуй	Ханцуйны доод хэсэгт 4 ширхэг товчтой байна.Товчны хэлбэр Дугуй байх	Хөр хөх	Товч хуванцар 100%
10	Ард тал	Пиджакны ард тал оноогүй битүү байна.	Хар хөх	

		Бүсэлхий хэсгээр нарийн танаастай байх		
<b>ХОЁР:Эмэгтэй пиджак</b>				
1	Гадна өнгө	Өнгө амархан алдахгүй , нийлэг бус хөвөн даавуун материал, тоос татахгүй үрчийхгүй байх -Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна. -Хүний биед дээд зэргээр тохиромжтой байх бөгөөд биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх	Хар хөх	
2	Дотор өнгө	-	Хар хөх	
3	Дотрын материал	Дотрын материалын зориулалт бүхий амархан сэмэрч гэмтэхээргүй материал, хөнгөн чанартай салхи нэвтрүүлдэг, будаг гардаггүй байх		Дотор нь 100% ацетат байна.
4	Зах, мөр	Зах нь хатуулгагүй мөр нь хатуулгагүй байх	Хар хөх	Захны өндөр 6см
5	Урд тал	Урд талдаа 2 ширхэг товчтой байна. Энгэрийн эсгэлтэд хөхний хэсгийн оруулга стандартын дагуу байх.	Хар хөх	Пиджакны доод талаас17см, Урд 2 товчны хоорондын зай 10 см байна
6	Халаас	Урд талын доод талд 2 ширхэг халаас байна.		Халаасны өндөр-17см халаасны хэмжээ-14см Халаасны гүн 14см
7	Лого	Урд талд: Энгэрийн карманы доод талд албаны лого байрлана.	Хар,шар өнгийн	Тусад нь ширж хатгаж бэлтгэсэн логог энгэрийн халааснаас доош 4см-н түвшинд халаасны эмжээртэй паралель оёсон байна
8	Ханцуй	Товчгүй байна	Хөр хөх	
9	Ард тал	Пиджакны ард тал оноогүй битүү байна. Бүсэлхий хэсгээр нарийн танаастай байх	Хөр хөх	
<b>ГУРАВ:Өмд/эрэгтэй/</b>				
1	Гадна өнгө	Өнгө амархан алдахгүй , нийлэг бус хөвөн даавуун материал, тоос татахгүй үрчийхгүй байх	Хар хөх	
2	Дотор өнгө	-Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна. -Хүний биед дээд зэргээр тохиромжтой байх бөгөөд биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх.	Хар хөх	
3	Манжетик	-Өмдний манжетка 6 ширхэг тэлээний гогцоотой байна.	Хар хөх	Халаасны өндөр-17см хойд талын өндөр 15см, 1товчтой
4	Урд тал	2 талдаа танаастай, цахилгаан тай, товч, дэгээтэй байна.	Хар хөх	Цахилгааны хэмжээ 14см, 1товчтой байна.
5	Халаас	Хажуу талдаа 2 далд, ташуу халаастай, хойд талын баруун талд 1 халаас байна.		Халаасны өндөр-17см хойд талын халаасны өндөр 15см,1товчтой байна.

<b>ДӨРӨВ.Юбка</b>				
1	Гадна өнгө	Өнгө амархан алдахгүй , нийлэг бус хөвөн даавуун материал, тоос татахгүй үрчийхгүй байх	Хар хөх	
2	Дотор өнгө	- Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна. -Хүний биед дээд зэргээр тохиромжтой байх бөгөөд биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх.	Хар хөх	Дотор нь 100% ацетат байна.
3	Манжетик	Юбканы манжетика тэлээний гогцоогүй байна.	Хар хөх	
4	Ар тал	Ар тал 1 товчтой, цахилгаантай, 1 оноотой байна	-	Цахилгааны урт хэмжээ 4см, онооны урт доод талаас 20см байна.

**ТАВ: Багц-2: ЦАГААН ЦАМЦ, ЗАНГИА**

1	Цамцны өнгө	Өнгө амархан алдахгүй , гандахгүй, нийлэг бус хөвөн даавуун материал байна.	Цагаан	
2		-Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна. -Цамц нь биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байна. -Цамц нь урт болон богино ханцуйтай 2 ширхэг байна. -Хажуу талдаа тайлтай байна. -Угааж цэвэрлэхэд агшихгүй байх.		
3	Халаас	Урд энгэртээ 2 халаастай байна. Халаасны "таг" товчтой байх , зэргийн тэмдэг зүүх хэсэгтэй байна.		Халаас нь тэгш өнцөг хэлбэртэй. Товчтой байна.
4	Мөр	Мөрдөстэй байна.Оёдлын бэхэлгээг цэвэр үзэмжтэй , чанартай гүйцэтгэсэн байх		Мөрдөс нь 1 товчтой байна.
5	Ханцуй	Урт ханцуйтай цамц 1 ширхэг		Урт ханцуй манжеткатай байна.

**ЗУРГАА.Зангиа**

1	Зангиа	Өнгө амархан алдахгүй. Цэвэр үзэмжтэй, стандартын дагуу оёсон байна 1. Эр зангиа /өргөн/ 2. Эм зангиа	Хар хөх	100% Силк материалаар бүтээгдсэн байна.
---	--------	---	---------	---

**ДОЛОО.БАГЦ-3: МАЙК**

1	Ноолууран майк	1. Боловсруулалтын технологийн чанарыг хангасан сүлжмэл , ямааны цэвэр 100%-н ноолууран орцтой бүтээгдэхүүн байна. 2. Майк нь оёдлын технологийн чанарын шаардлагыг хангасан, сүлжмэл утас нь хөврөхгүй байх. 3. Угааж цэвэрлэхэд агшиж , сунахгүй байх. Ханцуйгүй	Хар хөх	100% Ямааны ноолуур майк нь өнгө будгаа удаан хугацаагаар хадгалах чанартай байна.
2	Зах	Гурвалжин захтай		
3	Энгэр	Битүү энгэртэй байна.		

**2.НИЙЛҮҮЛЭХ ТОО ХЭМЖЭЭ**

№	Захиалах барааны нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж
1	Ноолууран майк	92	Ширхэг

2	Цагаан цамц ханцуйтай	Эрэгтэй 64	ширхэг
		Эмэгтэй 28	
3	Цагаан цамц ханцуйгүй	Эрэгтэй 64	Ширхэг
		Эмэгтэй 28	
4	Зангиа	92	Ширхэг
5	Дүрэмт хувцас	Эрэгтэй 64	хос
		Эмэгтэй 28	

Нислэгийн удирдагч, мэдээллийн ажилтны  
дүрэмт хувцас



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Иргэний нисэхийн ерөнхий газар)-ын дарга  
Л.Бямбасүрэн танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхой лолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших  
1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт  
2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх  
3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх  
4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа  
5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[моо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах  
6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр  
7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь  
8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах  
9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ  
10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд

**биелүүлээгү  
йгээс гэрээг  
цуцлах**

захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

**11.Маргааныг  
шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.



**НАЙМ ДУГААР БҮЛЭГ**  
**ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

---

<b>1. Тодорхойлолт</b> (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь <b>Иргэний нисэхийн ерөнхий газар</b> .
	1.1 (ж)	Ажлын талбай нь <b>Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба</b>
<b>2. Шалгалт туршилт</b> (ГЕН - 7)	7.0	Захиалагч техникийн шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж, туршсаны дараа барааг хүлээн авсанд тооцно.
<b>3. Баглаа боодол</b> (ГЕН - 8)	8.0	Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэх, тухайн бараа үйлдвэрлэгчийн шаардлагыг хангасан байна.
<b>4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт</b> (ГЕН - 9)	9.0	ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <sup>1</sup>
	9.3	“Монгол Улсын гаднаас санал болгосон бараа” (DDP):  1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;  2) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;  3) Барааг хүлээлгэн өгөхдөө алба хаагч тус бүрт дүрэмт хувцсыг тааруулан тохируулж, засварлаж өгөх; /гэрээнд заасан хугацааны дотор/  Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
<b>5. Гүйцэтгэлийн баталгаа</b> (ГЕН - 11)	11.1	Гүйцэтгэлийн баталгаа гэрээний үнийн 5 хувьтай тэнцэх дүнтэй байна.
<b>6. Төлбөр</b> (ГЕН - 14)		ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <sup>2</sup>
	14.4	“Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ:

---

<sup>1</sup>Эдгээр заалтуудыг зөвхөн жишээ болгож дурдсан / ба олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

<sup>2</sup> Энд дурдсан заалтууд болон хувиудыг зөвхөн жишээ болгож дурдсан бөгөөд /олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын мөрддөг жишиг/ тухайн бараа нийлүүлэлтийн онцлогт тохируулан өөрчилж болно.

1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилгаа төлбөрийн дүн нь 30% хүртэл хувь олгож болно. Урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил валютаар илэрхийлэгдсэн банкны батлан даалт буюу үл маргах нөхцөлтэйгээр банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн төлбөрийг хийнэ.
2. **Бараа хүлээн авахад төлөх төлбөр:** Бараа хүлээлгэж өгснөөс хойш нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үлдсэн төлбөрийг төлнө.
3. Гэрээний үнэ нь НӨАТ орсон үнэ болно.

7. Алданги оногдуулах (ГЕН - 17)	17.1	Нийлүүлэгчид алданги оногдуулах хувь <i>хоногт: гэрээний үнийн дүнгийн 0,5% байна.</i> Алдангийн нийт дүн: <i>Гэрээний үнийн 10%-иас хэтрэхгүй</i>
8. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 21)	21.0	Захиалагч болон нийлүүлэгч нь талуудын хооронд гарсан маргааныг Монгол улсын хуулийн дагуу шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ

---

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

### БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:  
\_\_\_\_\_

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.